



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2024 оны 01 сарын 03-ны  
өдрийн 6.5.30 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А6257

Улаанбаатар хот


Гэрээ шууд байгуулах аргын хэлэлцээ  
хийх дэг, тендер шалгаруулалтын жишиг  
баримт бичиг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 27 дугаар зүйлийн 27.6, 35 дугаар зүйлийн 35.16, 55 дугаар зүйлийн 55.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэрээ шууд байгуулах аргын хэлэлцээ хийхэд баримтлах дэг”-ийг нэгдүгээр, “Гэрээ шууд байгуулах аргаар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хууль, эрх зүйн газар (З.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Б.ЖАВХЛАН

САНГИЙН САЙДЫН АРХИВ  
ХУУЛБАР ҮНЭН  
Бүртгэлийн №. 2029  
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга  
Архивын эрхлэгч ..... Н. Аугл  
41 хуудас 2023 оны 12 сар 25 өдөр

9763000839